| | |
|---|---|
| **БАТЛАВ.** | **БАТЛАВ.** |
| **“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ** | **“ФАРМТРЕЙД” ХХК** |
| **ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ** | **ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.ТҮВШИНБАТ** |

# БАРАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ МРЦМ/202112336

№ ИК-2021-03-91 Улаанбаатар хот

Нэг талаас **“Монголросцветмет” ТӨҮГ** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **“Фармтрейд” ХХК** (цаашид “Нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 03 сарын 27 -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон Захиалагч, Нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь ***Эм, эмнэлэгийн хэрэгсэл*** (цаашид “бараа” гэх) ***16,778,330 (арван зургаан сая долоон зуун далан найман мянга гурван зуун гучин) төгрөгөөр*** /НӨАТ тооцсон/ (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн Нийлүүлэгчийн тендерийг доорхи тоо хэмжээ, үнийн дүнтэйгээр Хавсралт №1-д заасан барааг нийлүүлэхийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. ***Эм, эмнэлэгийн хэрэгсэл*** техникийн тодорхойлолт нь тендерийн бичиг баримтад заасны дагуу байна.
3. Захиалагч нь Барааны нийлүүлэлтийг ***16,778,330 (арван зургаан сая долоон зуун далан найман мянга гурван зуун гучин)*** **төгрөгийн** өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод заасан барааг гэрээ байгуулсанаас хойш 30 хоногт Incoterms 2010 DDP Бор-Өндөр УБҮ-т нийлүүлж хүлээлгэн өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “Гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

    Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
    Бусад шаардлагатай баримт бичиг;
    Тендер ба үнийн хуваарь;
    Гэрээний ерөнхий нөхцөл;
    Гэрээний тусгай нөхцөл;
    Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь
    Санхүүжилтын хуваарь
    Хавсралт №1
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу Захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гарч болох чанарын гологдол, гэмтэл согог, тоо хэмжээний дутагдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Нийлүүлэгчийн нийлүүлэх барааны гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр Нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

9. Тус гэрээ нь хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болж 1 жилийн турш хүчин төгөлдөр байх ба талууд гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн үед дуусгавар болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
| --- | --- |
| Худалдаа, эдийн засаг эрхэлсэн орлогч захирал<br>Н.Тэгшжаргал | Гүйцэтгэх захирал<br>Ц.Түвшинбат |
| ____________________ | ____________________ |
| Захиалагчийн хаяг: | Нийлүүлэгчийн хаяг: |
| **"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ**<br>Улаанбаатар хот, БЗД 22-р хороо,<br>Энхтайваны өргөн чөлөө – 98<br>Утас: 11-458072<br>Факс: 11-458380 | **"ФАРМТРЕЙД" ХХК**<br>Улаанбаатар хот, БЗД, 18-р хороо<br>13-р хороолол 12-92 тоот<br>Утас: 11-315383 |
| ХАС банк, дансны дугаар: 5001208361 | ХХБанк, данс: 499135029 |

PHARM TRADE LLC
ФАРМ ТРЕЙД ХХК
УЛААНБААТАР ХОТ

| | | |
| --- | --- | --- |
| Үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирал | __________ | М.Болдбаатар |
| ХЭЗХэлтсийн дарга | __________ | Б.Энхжин |
| Ерөнхий нягтлан бодогч | __________ | Д.Баярбат |
| Санхүүгийн хэлтсийн дарга | __________ | Н.Гантулга |
| ТЭЗШХэлтсийн дарга | __________ | И.Ганцэцэг |
| ҮТТХэлтсийн дарга | __________ | П.Хангал |
| **Хянасан:** ХАХНХ -ийн дарга | __________ | Д.Мэндбаяр |
| **Боловсруулсан:** ХАХНХ-ийн мэргэжилтэн | __________ | Г.Ням-Осор |
| ХЭЗХ-ийн мэргэжилтэн | __________ | Г.Жавхлантөр |

"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | | |
|---|---|---|
| **1. Шалгах болон турших** | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| **2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| **3. Оюуны өмчийн эрх** | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| **4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| **5. Баталгаат засварын хугацаа** | 5.1. | Нийлүүлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа ***[6]*** сар байна. |
| **6. Гэрээнд өөрчлөлт оруулах** | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| **7. Төлбөр** | 7.1. | Захиалагч төлбөрийг бараа хүлээн авснаас хойш ***[30]*** хоногийн дотор шуурхай хийнэ. |
| **8. Бараа нийлүүлэх хуваарь** | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| **9. Алданги оногдуулах** | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| **10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| **11. Маргааныг шийдвэрлэх** | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС
ХЯНАВ

# ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | | |
|---|---|---|
| **1. Шалгах болон турших (ГЕН – 1)** | 1.1. | [Үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ, баталгаат хугацаа.]<br>***Шаардлагатай***<br>Шалгалт ба туршилтыг барааг Захиалагчийн ажлын талбайд хүлээн авах үед техникийн шалгуур үзүүлэлтийн дагуу шалгана. Бараа нь үйлдвэрийн чанарын сертификаттай байна. |
| **2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** | 2.1. | Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) ннийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| **3. Баталгаат засвар (ГЕН-5)** | 5.1. | Баталгаат тусгай шаардлага.<br><br>Бараанд олгох баталгаат засварын хугацаа барааг нийлүүлснээс хойш 12 сар байна.<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| **4. Төлбөр (ГЕН – 7)** | 7.1. | Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн ***[100]***[1] хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| **5. Алданги оногдуулах (ГЕН - 9)**[2] | 9.1. | Алданги оногдуулах хувь: ***[0,1]***<br><br>Алдангийн нийт дүн: ***[Нийлүүлээгүй барааны үнийн дүнгийн 10%-иас ихгүй байна]*** |

[1] Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.
[2] Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

# ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт: *Эм, эмчилгээний материал, багаж хэрэгсэл*** нь дараах шаардлагыг хангасан байна.

- Тендерт оролцогч хуулийн этгээд нь эм, эмчилгээний багаж хэрэгсэл худалдан борлуулах импортлох тусгай зөвшөөрөлтэй байна.
- Тендерийн урилгын дагуу захиалагчийн худалдан авах эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. Савлагаа, шошгоны стандарт нь ДЭМБ-ийн эм үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хяналтын дүрэм (GMP)-ийн хамгийн сүүлийн шаардлагуудыг бүрэн хангасан байна.
- Бүтээгдэхүүний тодорхойлолтод эмийн хэлбэр /шахмал, тарил/уусмал болон нунтаг, тосон түрхлэг гэх мэт/ болон найрлага, тун хэмжээ /олон улсын нэгж {IU}, мг, процент)-г заана.
- Бүх эм нь баглаа боодол дээрээ үйлдвэрлэсэн он сар өдөр болон баталгаат хугацааг тодорхойлсон тэмдэглэлтэй байна.
- Эм, эмчилгээний материалын баталгаат хугацаа нь 2021-2021 оноос багагүй байна.
- Эмчилгээ, оношлогооны багаж хэрэгсэл нь ашиглагдаж байгаагүй шинэ байна.
- Эмчилгээний багаж хэрэгслүүд нь ашиглах заавар, гарын авлагатай байна.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл болон түүний савлалт, хаяглалтын материал нь (шил, хуванцар сав гэх мэт) тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Бүх савлагаа нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, савлах стандартыг хангаж дахин савлах боломжгүйгээр битүүмжлэгдсэн байна.

**“Бор-Өндөр” УБҮ-ийн Эмнэлгийн хэсгийн 2021 онд захиалах эмнэлгийн хэрэгслийн техникийн тодорхойлолт**

1. **Халууны шил**

   1.1 Бүтээгдэхүүний ангилал: Оношлогооны багаж
   1.2 Дижитал, түргэн хугацаанд халуун хэмжих боломжтой.
   1.3 Хэрэглэхэд хялбар, автоматаар унтардаг.
   1.4 Санах ойтой.
   1.5 Суга болон аманд үзэх боломжтой.
   1.6 Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажсан байх.



   1.7

2. **Пульсоксиметр**

2.1 Бүтээгдэхүүний ангилал: Оношлогооны
2.2 Хэрэглэхэд хялбар
2.3 Дэлгэц том, гэрэл сайтай
2.4 Том хүний




2.5

## 3. Яаралтай тусламжийн иж бүрдэл цүнх

3.1 Цүнхэнд

1. Гар отсос 1ш
2. Амбу 1ш
3. Е-маск 1ш
4. Сэхээний хэл дарагч 2ш
5. Халуун хэмжигч 1ш
6. Ам тэлэгч 1ш
7. 1 удаагийн тариур 2ш
8. Хэл баригч 1ш
9. Ариун скальпел 1ш
10. Ланцет 2ш
11. Модон хэл дарагч 5ш
12. Мэс заслын хайч 1 хос
13. Даавууны хямсаа 1 хос
14. Сүлбээр зүү 10 ш
15. Ариун бээлий 2 хос
16. Даралтын аппарат 1ш
17. Чагнуур 1ш
18. Бостон 1ш
19. Тарианы чангалуур 1ш
20. Мөсөн жин 2ш
21. Спирттэй салфетка 30 ш
22. Иодтой салфетка 10ш
23. Антисептик арчдас 5ш
24. Савантай алчуур 5ш

25. Мэдрэлийн алх 1ш
26. Лент 3ш
27. Нүдний ариун наалт 1ш
28. Гурвалжин алчуур 5ш
29. Ариун бинт 10ш
30. Хөвөн бөмбөлөг 5 багц
31. Хуруу лент 50ш
32. Даавуу үдэгч 20ш
33. Уян боолт 6см 3ш
34. Даралттай уян боолт дунд 2ш
35. Даралттай уян боолт том 1ш
36. Уян боолт жижиг 2ш
37. Уян боолт том 2ш
38. Яаралтай тусламжийн хөнжил 2ш
39. Үзгэн гэрэл 1ш
40. 1 удаагийн уут 3ш

3.2




"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС
ХЯНАВ

**4. Драйгерийн хошуу**

4.1 Alcoscan AL 9000L загварын драйгерийн нэг удаагийн хошуу

4.2



2. **Баглаа, боодол: DDP Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, "Бор-Өндөр" УБҮ нөхцлөөр нийлүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах онцгой журам шаардах бол хадгалалтын горим алдагдахаас сэргийлэн зааврын дагуу тээвэрлэж нийлүүлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр хүлээлгэн өгч бараа** хүлээлгэн өгсөн акт үйлдэнэ.
3. **Бараа хүргэх газар: Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, "Бор-Өндөр" УБҮ**

**Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээ байгуулснаас хойш 20 хоногийн дотор

**Эм, эмнэлгийн хэрэгслийн жишиг техникийн тодорхойлолт**

| | |
|---|---|
| **1. Бүтээгдэхүүний болон баглаа боодлын тодорхойлолт** | а. Тендерийн урилгын дагуу захиалагчийн худалдан авах эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эмнэлгийн хэрэгсэл нь зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад орсон байна.<br>Савлагаа, шошгоны стандарт нь ДЭМБ-ийн эм үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хяналтын дүрэм (GMP)-ийн хамгийн сүүлийн шаардлагуудыг бүрэн хангасан байна. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг нийлүүлэх тендерт оролцогч түүнийг импортлох тусгай зөвшөөрөл авсан байна.<br>б. Бүтээгдэхүүний тодорхойлолтод эмийн хэлбэр /шахмал, тарил/уусмал болон нунтаг, тосон түрхлэг гэх мэт/ болон найрлага, тун хэмжээ /олон улсын нэгж {IU}, мг, процент)-г заана.<br>в. Эм, эмнэлгийн хэрэгсэл болон түүний савлалт, хаяглалтын материал нь (шил, хуванцар сав гэх мэт) тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Бүх савлагаа нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, савлах стандартыг хангаж дахин савлах боломжгүйгээр битүүмжлэгдсэн байна. Захиалагч аливаа нэмэлт шаардлагыг тусгайлан тайлбарласан байна.<br>г. Шошго болон хэрэглэх заавар нь захиалагчийн тусгайлан заасан хэл дээр байна.<br>д. Хөлдөөх эсхүл тодорхой хэмийг тогтвортой байлгах зэрэг хадгалалтын тусгай горим шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн шошго болон сав, баглаа боодолд үүнийг тусгайлан зааж тээвэрлэлтийн явцад мөрдөнө.<br>е. Гэрээ байгуулах эрх авсан нийлүүлэгч захиалагч шаардсан тохиолдолд тухайн бүтээгдэхүүний тайлбар зааварчилгааг тендерийн хэл дээр хөрвүүлнэ. |
| **2. Хаяглах заавар** | 2.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн үндсэн савлагаан дээрх шошго нь GMP стандартыг хангасан байх бөгөөд дараах мэдээллийг агуулсан байна:<br>1) Олон улсын нэр (INN) болон худалдааны нэрийн дээр байнга бичигдэх ерөнхий нэршлийг бичсэн байна. Худалдааны нэр нь ерөнхий нэршлээс илүү тод ба том бичигдэх ёсгүй;<br>2) Эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);<br>3) үндсэн үйлчлэгч бодис, түүний нэгж тун дахь хэмжээ;<br>4) зохих фармакопейн стандарт;<br>5) захиалагч шаардлагатай гэж үзвэл захиалагчийн тэмдэг, код, бүртгэлийн дугаар;<br>6) баглаа бүр дэх бүтээгдэхүүний орц хэмжээ;<br>7) хэрэглэх заавар;<br>8) хадгалалтын онцгой нөхцөл /шаардлага;<br>9) цувралын дугаар;<br>10) үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);<br>11) үйлдвэрийн нэр ба хаяг;<br>12) бусад шаардлагатай сануулга.<br><br>1.2 Гаднах савлагааны дээр дээрх мэдээллийг мөн тэмдэглэсэн байна. |

| | | |
|---|---|---|
| **3. Сав, баглаа боодлын таних тэмдэг** | 3.1 | Бүх баглаа боодолд доорх мэдээллийг тусгана:<br>6) захиалагчийн бүртгэлийн дугаар;<br>7) эмийн ерөнхий нэршил;<br>8) эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);<br>9) үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);<br>10) цувралын дугаар;<br>11) нэгж боодол дахь тоо хэмжээ ;<br>12) хадгалалтын тусгай заавар;<br>13) үйлдвэрийн нэр ба хаяг;<br>14) бусад шаардлагатай мэдээлэл. |
| | 3.2 | Боодол бүр нь нэгээс илүүгүй бүтээгдэхүүний цувралыг агуулсан байна. |
| **4. Онцлог таних тэмдэг** | 4.1 | Захиалагч нь нийлүүлж буй бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяганд өөрийн таних тэмдгийг тусгуулах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгах замаар нийлүүлэгчид тавьж болно. Түүний загвар болон дэлгэрэнгүй тайлбарыг захиалагч тендер шалгаруулалтын өмнө бэлэн болгосон байх бөгөөд гэрээ байгуулах эрх олгох үед эцэслэн баталгаажуулж нийлүүлэгчид өгнө. |
| **5. Барааны чанарын баталгааны стандарт** | 5.1 | Шалгарсан тендерт оролцогч шаардсан тохиолдолд захиалагчид дараах мэдээлэл, баримт бичгийг ирүүлнэ:<br>1. нийлүүлэгдэж буй бараанд хамаарах эмийн нэр төрөл бүрийн тоо хэмжээ, химийн шинжилгээ, ариун чанар, халууруулах чанар, хоруу чанарын болон бусад шинжилгээний талаар ДЭМБ-ын жишиг цувралын болон бүтээгдэхүүний сертификат;<br>2. аль нэг эсхүл бүх шинжилгээний аргачлал (GMP эсхүл ISO);<br>3. аль нэгэн онцгойлсон эмийн био-хүртээмж болон/эсхүл био-эквивалентын нотолгоо; Энэ мэдээллийг зөвхөн хатуу нууцлалын доор ирүүлнэ.<br>4. худалдаанд зориулсан савлалттай холбогдуулж хүчинтэй байх хугацаа дуусах огноо болон тогтвортой чанарыг илэрхийлсэн бусад үзүүлэлтийг тодорхойлсон үндэслэл<br>5. барааны дээж. |
| | 5.2 | Шалгарсан тендерт оролцогч нь захиалагч шаардсан тохиолдолд үйлдвэрлэлт нь GMP-ийн хадгалалтын шаардлагууд болон чанарын хяналтын механизмд нийцэж буй эсэхтэй танилцуулах зорилгоор түүнийг үйлдвэрлэлийн болон агуулахын байранд нэвтрэх боломжоор хангана. |

**Эм, эмнэлгийн хэрэгслийг багцлах санамж**

Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааны хувьд салбарын онцлог шинж чанараас шалтгаалан зөвхөн бүтээгдэхүүний нэр төрөлд үндэслэсэн стандарт ангиллыг ашиглаж бүтээгдэхүүний багцыг өрсөлдөөнийг хангахуйцаар оновчтой тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

"МОНГОЛРОС... хууль, эрх зүйн келтес ХУУЛАВ

Тиймээс эмүүдийг фармакологийн буюу өвчний ангиллаар, эмнэлгийн хэрэгслийг тухайн бараа хэрэглэгдэх нарийн мэргэжлийн тусламжийн төрлөөр багцалж болно. Мөн ижил нэр төрлийн бүтээгдэхүүнийг тэдгээрийг хадгалах хугацаа, хэрэглэх хэмжээ зэргийг сайтар харгалзан багцалж болно. Зайлшгүй шаардлагатай эм худалдан авах ажиллагаанд ашиглаж болох багцын загварыг хавсралтад үзүүллээ. Багц нь аль болох жижиг байх нь зохимжтой.

Эмнэлгийн хэрэгслийг багцлахдаа Эрүүл мэндийн сайдын 2005 оны 325 дугаар тушаалаар баталсан зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг үндэслэн дараах ангиллыг ашиглана. Үүнд:

1) Ороох боох материал
2) Тариур зүү, мэс заслын хутга
3) Оёдлын материал
4) Хамгаалалтын хувцас
5) Катетер, гуурс
6) Рентген
7) Унтуулгын хэрэгсэл
8) Хэт авианы хэрэгсэл
9) Шүд, эрүү нүүрний хэрэгсэл
10) Нүдний хэрэгсэл
11) Чих хамар хоолойн хэрэгсэл
12) Уламжлалт анагаах ухаан
13) Эх барих, эмэгтэйчүүдийн хэрэгсэл
14) Бусад.

Нэг төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг илэрхийлэхэд олон тооны худалдааны нэр болон барааны тэмдгүүд хэрэглэгддэг учир тендер шалгаруулалтын багцыг хийхдээ тухайн эмийн олон улсын нэршлийг ашиглах нь зүйтэй.

Энэ нь мөн өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтыг хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг худалдааны нэрээр ирүүлж шалгарсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчоос худалдааны нэрийн дээд талд том үсгээр, илүү тодоор олон улсын нэршил буюу ерөнхий нэрийг бүх хаяглалт дээр харуулахыг шаардах хэрэгтэй.

## Хавсралт №1

**2021 оны __ сарын __** **№**

| № | Нэрс | Хэмжих нэгж | Хадгалах Хугацаа | Нийт тоо | Нэгж Үнэ | Нийт Үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Sol Цефазолин 1.0 | фл | 2 жил | 5 | 1,600.00 | 8,000.00 |
| 2 | Sol Метрогел 100мл | фл | 2 жил | 4 | 1,800.00 | 7,200.00 |
| 3 | Sol Баралгин 5 мл №5 | кроп | 2 жил | 1 | 7,500.00 | 7,500.00 |
| 4 | Sol Магний сульфат 25%-10 мл №10 | кроп | 2 жил | 1 | 4,900.00 | 4,900.00 |
| 5 | Sol Дицинон 2 мл | амп | 2 жил | 10 | 1,850.00 | 18,500.00 |
| 6 | Sol Панангин 10 мл №5 | кроп | 2 жил | 2 | 21,000.00 | 42,000.00 |
| 7 | Sol Пирацетам 20%- 5 мл №10 | кроп | 2 жил | 1 | 4,300.00 | 4,300.00 |
| 8 | Sol Рибоксин 2%- 5 мл №10 | кроп | 2 жил | 3 | 4,300.00 | 12,900.00 |
| 9 | Sol Диклоденк 75 мг №10 | кроп | 2 жил | 2 | 21,000.00 | 42,000.00 |
| 10 | Sol Салбутамол 10 мл цацлага | фл | 2 жил | 1 | 12,000.00 | 12,000.00 |
| 11 | Sol Лидокайн 2%- 2мл №10 | кроп | 2 жил | 1 | 2,800.00 | 2,800.00 |
| 12 | Sol ККБ 50 мг №5 | кроп | 2 жил | 8 | 9,500.00 | 76,000.00 |
| 13 | Sol Витамин С 5%- 2мл №10 | кроп | 2 жил | 7 | 3,100.00 | 21,700.00 |
| 14 | Sol Мидокалм-1 мл №5 | кроп | 2 жил | 2 | 25,000.00 | 50,000.00 |
| 15 | Sol Кальцийн глюконат 10%- 10 мл №10 | кроп | 2 жил | 1 | 5,600.00 | 5,600.00 |
| 16 | Sol Эуфиллин2.4%-10 мл №10 | кроп | 2 жил | 2 | 3,800.00 | 7,600.00 |
| 17 | Sol Анальгин-2 мл №10 | кроп | 2 жил | 4 | 5,700.00 | 22,800.00 |
| 18 | Sol Димедрол-1 мл №10 | кроп | 2 жил | 4 | 1,900.00 | 7,600.00 |
| 19 | Sol Дибазол 1%-5 мл №10 | кроп | 2 жил | 1 | 3,900.00 | 3,900.00 |
| 20 | Sol Маннитол 250 мл | фл | 2 жил | 2 | 3,700.00 | 7,400.00 |
| 21 | Sol Рингер-500 мл | фл | 2 жил | 12 | 3,700.00 | 44,400.00 |
| 22 | Sol Фурасемид 2 мл №10 | кроп | 2 жил | 2 | 1,800.00 | 3,600.00 |
| 23 | Sol Натрий хлорид 0,9%- 100 мл | фл | 2 жил | 30 | 1,600.00 | 48,000.00 |
| 24 | Sol Натрий хлорид 0,9%- 250 мл | фл | 2 жил | 15 | 1,650.00 | 24,750.00 |
| 25 | Sol Натрий хлорид 0,9%- 500 мл | фл | 2 жил | 6 | 1,850.00 | 11,100.00 |
| 26 | Sol Спирт 76% | Литр | 2 жил | 20 | 6,100.00 | 122,000.00 |
| 27 | Sol Спирт 76%- 30 мл | фл | 2 жил | 840 | 900.00 | 756,000.00 |
| 28 | Sol Иод 30 мл | фл | 2 жил | 820 | 1,600.00 | 1,312,000.00 |
| 29 | Sol Перкис 3% | фл | 2 жил | 7 | 1,700.00 | 11,900.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | Sol Тамедин 0.7% - 300мл | фл | 2 жил | 16 | 1,980.00 | 31,680.00 |
| 31 | Долоогоны ханд | ширхэг | 2 жил | 8 | 1,300.00 | 10,400.00 |
| 32 | Т. Диклоденк 100мг №10 | Уп | 2 жил | 120 | 4,000.00 | 480,000.00 |
| 33 | Т. Ибупрофейн 400 мг №10 | Уп | 2 жил | 840 | 1,100.00 | 924,000.00 |
| 34 | Т. Уголь акт 250 мг №10 | уп | 2 жил | 840 | 700.00 | 588,000.00 |
| 35 | Т. Церукал 10мг №10 | уп | 2 жил | 10 | 7,200.00 | 72,000.00 |
| 36 | Т. Атенолол 50 мг №10 | уп | 2 жил | 20 | 2,500.00 | 50,000.00 |
| 37 | Т. Нифедипин 10мг №10 | уп | 2 жил | 20 | 1,500.00 | 30,000.00 |
| 38 | Т. Диротон 10мг №28 | кроп | 2 жил | 7 | 21,000.00 | 147,000.00 |
| 39 | Т. Конкор 5 мг №30 | кроп | 2 жил | 2 | 20,000.00 | 40,000.00 |
| 40 | Т. Нитроглицерин 0.5 №40 | кроп | 2 жил | 2 | 4,500.00 | 9,000.00 |
| 41 | Т. Мезимфорте №20 | кроп | 2 жил | 420 | 4,500.00 | 1,890,000.00 |
| 42 | Т. Панзинорм форте №21 | кроп | 2 жил | 4 | 16,500.00 | 66,000.00 |
| 43 | Caps. Хлорофенакол 500 мг №10 | уп | 2 жил | 20 | 2,750.00 | 55,000.00 |
| 44 | Т. Имопек №10 | Уп | 2 жил | 30 | 1,800.00 | 54,000.00 |
| 45 | Т. Пантопразол 40 мг №28 | кроп | 2 жил | 4 | 21,000.00 | 84,000.00 |
| 46 | Т. Проколд №6 | уп | 2 жил | 888 | 900.00 | 799,200.00 |
| 47 | Т. Септолет №16 | кроп | 2 жил | 12 | 9,500.00 | 114,000.00 |
| 48 | Т. Валидол №6 | уп | 2 жил | 770 | 1,600.00 | 1,232,000.00 |
| 49 | Т. Цетризин 10мг №10 | уп | 2 жил | 40 | 1,700.00 | 68,000.00 |
| 50 | Т. Цитромон 500мг №10 | уп | 2 жил | 630 | 600.00 | 378,000.00 |
| 51 | Маск /нэг удаагийн/ | ширхэг | 3 жил | 500 | 290.00 | 145,000.00 |
| 52 | Лейкопластырь | ширхэг | 3 жил | 6 | 2,800.00 | 16,800.00 |
| 53 | Тариур 3.0 | ширхэг | 3 жил | 300 | 180.00 | 54,000.00 |
| 54 | Тариур 5.0 | ширхэг | 3 жил | 100 | 200.00 | 20,000.00 |
| 55 | Тариур 10.0 | ширхэг | 3 жил | 300 | 300.00 | 90,000.00 |
| 56 | Тариур- 20.0 | ширхэг | 3 жил | 50 | 400.00 | 20,000.00 |
| 57 | Дуслын систем | ширхэг | 3 жил | 100 | 500.00 | 50,000.00 |
| 58 | Зүү 23G №100 | хайрцаг | 3 жил | 2 | 8,200.00 | 16,400.00 |
| 59 | Викрил утас | ширхэг | 3 жил | 10 | 6,700.00 | 67,000.00 |
| 60 | Чих цэвэрлэгч савх | ширхэг | 3 жил | 12 | 550.00 | 6,600.00 |
| 61 | Бээлий нэг удаагийн № 50 хос | хайрцаг | 3 жил | 32 | 30,000.00 | 960,000.00 |
| 62 | Хөвөн | ширхэг | 3 жил | 160 | 1,600.00 | 256,000.00 |
| 63 | Бинт 7*14 | ширхэг | 3 жил | 890 | 2,000.00 | 1,780,000.00 |
| 64 | Шархны наалт 8*9 | ширхэг | 3 жил | 50 | 1,200.00 | 60,000.00 |
| 65 | Пластерь цаасан | ширхэг | 3 жил | 16 | 850.00 | 13,600.00 |
| 66 | Хуруу лент №50 | кроп | 3 жил | 160 | 1,800.00 | 288,000.00 |
| 67 | Аюулгүй хайрцаг | ширхэг | 3 жил | 28 | 3,600.00 | 100,800.00 |
| 68 | Sol Дексаметазон нүдний дусаалга | фл | 2 жил | 4 | 8,600.00 | 34,400.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 69 | Sol Отривин 10 мл | фл | 2 жил | 4 | 15,000.00 | 60,000.00 |
| 70 | Сахарын тест /CareSens N/ №50 | хайрцаг | 2 жил | 2 | 65,000.00 | 130,000.00 |
| 71 | Хүчилтөрөгчийн гуурс /том хүний/ | ширхэг | 3 жил | 12 | 7,500.00 | 90,000.00 |
| 72 | Өндөг цоологч /Lancet/ №100 | хайрцаг | 3 жил | 1 | 4,500.00 | 4,500.00 |
| 73 | Панфеникол 5 гр | ширхэг | 2 жил | 3 | 7,500.00 | 22,500.00 |
| 74 | Драйгерийн хошуу | ширхэг | | 120 | 4,000.00 | 480,000.00 |
| 75 | Хутганы ир | ширхэг | 3 жил | 10 | 2,500.00 | 25,000.00 |
| 76 | Хоросол /ORS/ | ширхэг | 2 жил | 880 | 650.00 | 572,000.00 |
| 77 | Халууны шил электрон | ширхэг | | 40 | 18,000.00 | 720,000.00 |
| 78 | Пульсоксиметр /том хүний/ | ширхэг | | 1 | 75,000.00 | 75,000.00 |
| 79 | Яаралтай тусламжийн иж бүрдэл цүнх | ширхэг | | 1 | 800,000.00 | 800,000.00 |
| | Нийт Дүн НӨАТ тооцсон: | | | | | 16,778,330.00 |

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Худалдаа, эдийн засаг эрхэлсэн орлогч захирал
Н.Тэгшжаргал

Захиалагчийн хаяг:

**"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ**
Улаанбаатар хот, БЗД 22-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө – 98
Утас: 11-458072
Факс: 11-458380

ХАС банк, дансны дугаар: 5001208361

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Гүйцэтгэх захирал
Ц.Түвшинбат

PHARM TRADE LLC

Нийлүүлэгчийн хаяг:

**"ФАРМТРЕЙД" ХХК**
Улаанбаатар хот, БЗД, 18-р хороо
13-р хороолол 12-92 тоот
Утас: 11-315383

ХХБанк, данс: 499135029

Нэмэгдсэн өртгийн
албан татвар төлөгчийн

# ГЭРЧИЛГЭЭ №0016949

Үндэсний татварын алба

Татвар төлөгчийн дугаар: 5 2 5 8 9 7 9

Нэр: "Фармтрейд" ХХК

| | |
|---|---|
| Улсын бүртгэлд бүртгэгдсэн он, сар, өдөр | 2008.09.19 |
| Үйл ажиллагааны чиглэл | Гадаад, дотоод худалдаа |
| | Эмийн бөөний төв |
| | |
| Байгууллагын хаяг, утас | БЗД. 18 -р хороо.13 хорoолын 12 - 92 тоот |
| Удирдлагын овог, нэр, утас | Р. Мөнхсайхан<br>Утас: 315383, 99118243 |
| Харилцах банк, дансны дугаар | ХХБ - 499135029 |
| | |
| | |
| | |

Бүртгэж гэрчилгээ олгосон: БАЯНЗҮРХ
Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга
/ Д.Готов /

2009 оны 05 сарын 01 өдөр

# ҮНИЙН САНАЛ

Огноо: 2021/02/24

НТШ-ын дугаар: МРЦМ/202112336

Хуудасны тоо 3

ТӨӨЗ-ны 16-д засан валютаар

| № | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Sol Цефазолин 1.0 | ОХУ | 5 | 1440 | 7200 | 800 | 8000 |
| 2 | Sol Метрогел 100мл | БНХАУ | 4 | 1620 | 6480 | 720 | 7200 |
| 3 | Sol Баралгин 5 мл №5 | ОХУ | 1 | 6750 | 6750 | 750 | 7500 |
| 4 | Sol Магний сульфат 25%-10 мл №10 | ОХУ | 1 | 4410 | 4410 | 490 | 4900 |
| 5 | Sol Дицинон 2 мл | Нидерланд | 10 | 1665 | 16650 | 1850 | 18500 |
| 6 | Sol Панангин 10 мл №5 | Унгар | 2 | 18900 | 37800 | 4200 | 42000 |
| 7 | Sol Пирацетам 20%- 5 мл №10 | ОХУ | 1 | 3870 | 3870 | 430 | 4300 |
| 8 | Sol Рибоксин 2%- 5 мл №10 | ОХУ | 3 | 3870 | 11610 | 1290 | 12900 |
| 9 | Sol Диклоденк 75 мг №10 | Герман | 2 | 18900 | 37800 | 4200 | 42000 |
| 10 | Sol Салбутамол 10 мл цацлага | ОХУ | 1 | 10800 | 10800 | 1200 | 12000 |
| 11 | Sol Лидокайн 2%- 2мл №10 | ОХУ | 1 | 2520 | 2520 | 280 | 2800 |
| 12 | Sol ККБ 50 мг №5 | ОХУ | 8 | 8550 | 68400 | 7600 | 76000 |
| 13 | Sol Витамин С 5%- 2мл №10 | Монгол | 7 | 2790 | 19530 | 2170 | 21700 |
| 14 | Sol Мидокалм-1 мл №5 | Унгар | 2 | 22500 | 45000 | 5000 | 50000 |
| 15 | Sol Кальцийн глюконат 10%-10 мл №10 | БНХАУ | 1 | 5040 | 5040 | 560 | 5600 |
| 16 | Sol Эуфиллин2.4%-10 мл №10 | ОХУ | 2 | 3420 | 6840 | 760 | 7600 |
| 17 | Sol Анальгин-2 мл №10 | Монгол | 4 | 5130 | 20520 | 2280 | 22800 |
| 18 | Sol Димедрол-1 мл №10 | Монгол | 4 | 1710 | 6840 | 760 | 7600 |
| 19 | Sol Дибазол 1%-5 мл №10 | ОХУ | 1 | 3510 | 3510 | 390 | 3900 |
| 20 | Sol Маннитол 250 мл | Монгол | 2 | 3330 | 6660 | 740 | 7400 |
| 21 | Sol Рингер-500 мл | Монгол | 12 | 3330 | 39960 | 4440 | 44400 |
| 22 | Sol Фурасемид 2 мл №10 | Монгол | 2 | 1620 | 3240 | 360 | 3600 |

**Тендерт оролцогчийн нэр: "Фарм трейд" ХХК**

Огноо: 2021/02/24
НТШ-ын дугаар: МРЦМ/202112336

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Sol Натрий хлорид 0,9%- 100 мл | Монгол | 30 | 1440 | 43200 | 4800 | 48000 |
| 24 | Sol Натрий хлорид 0,9%- 250 мл | Монгол | 15 | 1485 | 22275 | 2475 | 24750 |
| 25 | Sol Натрий хлорид 0,9%- 500 мл | Монгол | 6 | 1665 | 9990 | 1110 | 11100 |
| 26 | Sol Спирт 76% | Монгол | 20 | 5490 | 109800 | 12200 | 122000 |
| 27 | Sol Спирт 76%- 30 мл | Монгол | 840 | 810 | 680400 | 75600 | 756000 |
| 28 | Sol Иод 30 мл | Монгол | 820 | 1440 | 1180800 | 131200 | 1312000 |
| 29 | Sol Перкис 3% | Монгол | 7 | 1530 | 10710 | 1190 | 11900 |
| 30 | Sol Тамедин 0.7% - 300мл | Монгол | 16 | 1782 | 28512 | 3168 | 31680 |
| 31 | Долоогоны ханд | Монгол | 8 | 1170 | 9360 | 1040 | 10400 |
| 32 | Т. Диклоденк 100мг №10 | Герман | 120 | 3600 | 432000 | 48000 | 480000 |
| 33 | Т. Ибупрофейн 400 мг №10 | БНХАУ | 840 | 990 | 831600 | 92400 | 924000 |
| 34 | Т. Уголь акт 250 мг №10 | ОХУ | 840 | 630 | 529200 | 58800 | 588000 |
| 35 | Т. Церукал 10мг №10 | ОХУ | 10 | 6480 | 64800 | 7200 | 72000 |
| 36 | Т. Атенолол 50 мг №10 | Герман | 20 | 2250 | 45000 | 5000 | 50000 |
| 37 | Т. Нифедипин 10мг №10 | Энэтхэг | 20 | 1350 | 27000 | 3000 | 30000 |
| 38 | Т. Диротон 10мг №28 | Унгар | 7 | 18900 | 132300 | 14700 | 147000 |
| 39 | Т. Конкор 5 мг №30 | Нидерланд | 2 | 18000 | 36000 | 4000 | 40000 |
| 40 | Т. Нитроглицерин 0.5 №40 | ОХУ | 2 | 4050 | 8100 | 900 | 9000 |
| 41 | Т. Мезимфорте №20 | ОХУ | 420 | 4050 | 1701000 | 189000 | 1890000 |
| 42 | Т. Панзинорм форте №21 | ОХУ | 4 | 14850 | 59400 | 6600 | 66000 |
| 43 | Caps. Хлорофенакол 500 мг №10 | БНХАУ | 20 | 2475 | 49500 | 5500 | 55000 |
| 44 | Т. Имопек №10 | Индонез | 30 | 1620 | 48600 | 5400 | 54000 |
| 45 | Т. Пантопразол 40 мг №28 | Польш | 4 | 18900 | 75600 | 8400 | 84000 |
| 46 | Т. Проколд №6 | Энэтхэг | 888 | 810 | 719280 | 79920 | 799200 |
| 47 | Т. Септолет №16 | Нидерланд | 12 | 8550 | 102600 | 11400 | 114000 |
| 48 | Т. Валидол №6 | ОХУ | 770 | 1440 | 1108800 | 123200 | 1232000 |
| 49 | Т. Цетризин 10мг №10 | Энэтхэг | 40 | 1530 | 61200 | 6800 | 68000 |
| 50 | Т. Цитромон 500мг №10 | Монгол | 630 | 540 | 340200 | 37800 | 378000 |
| 51 | Маск /нэг удаагийн/ | БНХАУ | 500 | 261 | 130500 | 14500 | 145000 |

Тендерт оролцогчийн нэр: "Фарм трейд" ХХК

Огноо: 2021/02/24
НТШ-ын дугаар: МРЦМ/202112336

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | Лейкопластырь | ОХУ | 6 | 2520 | 15120 | 1680 | 16800 |
| 53 | Тариур 3.0 | Вьетнам | 300 | 162 | 48600 | 5400 | 54000 |
| 54 | Тариур 5.0 | Вьетнам | 100 | 180 | 18000 | 2000 | 20000 |
| 55 | Тариур 10.0 | Вьетнам | 300 | 270 | 81000 | 9000 | 90000 |
| 56 | Тариур- 20.0 | Вьетнам | 50 | 360 | 18000 | 2000 | 20000 |
| 57 | Дуслын систем | БНХАУ | 100 | 450 | 45000 | 5000 | 50000 |
| 58 | Зүү 23G №100 | БНСУ | 2 | 7380 | 14760 | 1640 | 16400 |
| 59 | Викрил утас | БНХАУ | 10 | 6030 | 60300 | 6700 | 67000 |
| 60 | Чих цэвэрлэгч савх | БНХАУ | 12 | 495 | 5940 | 660 | 6600 |
| 61 | Бээлий нэг удаагийн № 50 хос | Тайланд | 32 | 27000 | 864000 | 96000 | 960000 |
| 62 | Хөвөн | БНХАУ | 160 | 1440 | 230400 | 25600 | 256000 |
| 63 | Бинт 7*14 | БНХАУ | 890 | 1800 | 1602000 | 178000 | 1780000 |
| 64 | Шархны наалт 8*9 | БНХАУ | 50 | 1080 | 54000 | 6000 | 60000 |
| 65 | Пластерь цаасан | БНХАУ | 16 | 765 | 12240 | 1360 | 13600 |
| 66 | Хуруу лент №50 | БНСУ | 160 | 1620 | 259200 | 28800 | 288000 |
| 67 | Аюулгүй хайрцаг | Монгол | 28 | 3240 | 90720 | 10080 | 100800 |
| 68 | Sol Дексаметазон нүдний дусаалга | ОХУ | 4 | 7740 | 30960 | 3440 | 34400 |
| 69 | Sol Отривин 10 мл | Нидерланд | 4 | 13500 | 54000 | 6000 | 60000 |
| 70 | Сахарын тест /CareSens N/ №50 | БНСУ | 2 | 58500 | 117000 | 13000 | 130000 |
| 71 | Хүчилтөрөгчийн гуурс /том хүний/ | БНХАУ | 12 | 6750 | 81000 | 9000 | 90000 |
| 72 | Өндөг цоологч /Lancet/ №100 | БНХАУ | 1 | 4050 | 4050 | 450 | 4500 |
| 73 | Панфеникол 5 гр | Монгол | 3 | 6750 | 20250 | 2250 | 22500 |
| 74 | Драйгерийн хошуу | БНСУ | 120 | 3600 | 432000 | 48000 | 480000 |
| 75 | Хутганы ир | БНХАУ | 10 | 2250 | 22500 | 2500 | 25000 |
| 76 | Хоросол /ORS/ | Монгол | 880 | 585 | 514800 | 57200 | 572000 |
| 77 | Халууны шил электрон | БНХАУ | 40 | 16200 | 648000 | 72000 | 720000 |
| 78 | Пульсоксиметр /том хүний/ | БНХАУ | 1 | 67500 | 67500 | 7500 | 75000 |
| 79 | Яаралтай тусламжийн иж бүрдэл цүнх | БНХАУ | 1 | 720000 | 720000 | 80000 | 800000 |
| Тендерийн нийт үнэ | | | | | 15100497 | 1677833 | 16778330 |

Тендерт оролцогчийн нэр: "Фарм трейд" ХХК

# САНАЛ БОЛГОЖ БУЙ БАРААНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Огноо: 2021/02/24

НТШ-ын дугаар: МРЦМ/202112336

Хуудасны тоо 3

| № | Нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | Sol Цефазолин 1.0 | фл | 5 | Бор-Өндөр УБҮ | Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор | | Гэрээ байгуулснаас хойш 20 хоногийн дотор |
| 2 | Sol Метрогел 100мл | фл | 4 | | | | |
| 3 | Sol Баралгин 5 мл №5 | кроп | 1 | | | | |
| 4 | Sol Магний сульфат 25%-10 мл №10 | кроп | 1 | | | | |
| 5 | Sol Дицинон 2 мл | амп | 10 | | | | |
| 6 | Sol Панангин 10 мл №5 | кроп | 2 | | | | |
| 7 | Sol Пирацетам 20%- 5 мл №10 | кроп | 1 | | | | |
| 8 | Sol Рибоксин 2%- 5 мл №10 | кроп | 3 | | | | |
| 9 | Sol Диклоденк 75 мг №10 | кроп | 2 | | | | |
| 10 | Sol Салбутамол 10 мл цацлага | фл | 1 | | | | |
| 11 | Sol Лидокайн 2%- 2мл №10 | кроп | 1 | | | | |
| 12 | Sol ККБ 50 мг №5 | кроп | 8 | | | | |
| 13 | Sol Витамин С 5%- 2мл №10 | кроп | 7 | | | | |
| 14 | Sol Мидокалм-1 мл №5 | кроп | 2 | | | | |
| 15 | Sol Кальцийн глюконат 10%-10 мл №10 | кроп | 1 | | | | |
| 16 | Sol Эуфиллин2.4%-10 мл №10 | кроп | 2 | | | | |
| 17 | Sol Анальгин-2 мл №10 | кроп | 4 | | | | |
| 18 | Sol Димедрол-1 мл №10 | кроп | 4 | | | | |
| 19 | Sol Дибазол 1%-5 мл №10 | кроп | 1 | | | | |
| 20 | Sol Маннитол 250 мл | фл | 2 | | | | |
| 21 | Sol Рингер-500 мл | фл | 12 | | | | |
| 22 | Sol Фурасемид 2 мл №10 | кроп | 2 | | | | |

Тендерт оролцогчийн нэр: "Фарм трейд"

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ**
**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

*2021 оны 02-р сарын 25-ны өдөр* *№ МРЦМ/202112433-1* *Улаанбаатар хот*

"Монголросцветмет" ТӨҮГ-ын Захирлын 2021 оны 02-р сарын 10-ны өдрийн А/148 тоот тушаалаар томилогдсон үнэлгээний хорооны гишүүдийн хурал 2021 оны 02-р сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минутад "Монголросцветмет" ТӨҮГ-ын 301 тоот хурлын танхимд эхлэв.

Хуралд оролцсон:

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Н.Гантулга, Санхүүгийн хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Ж.Бямбажав, ХАБЭА хариуцсан ерөнхий мэргэжилтэн |
| Гишүүд: | Б.Бадамцэнд, ЗААХ-ийн ахлах мэргэжилтэн |
| | А.Энхцэцэг, "Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ-ын гишүүн /зөвшилцсөнөөр/ |
| | Ц.Цэрэндаш , "Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ-ын гишүүн /зөвшилцсөнөөр/ |

<u>Хэлэлцсэн асуудал:</u>

"Монголросцветмет" ТӨҮГ-т "Амны хаалт" нийлүүлэх МРЦМ/202112433 дугаар бүхий нээлттэй сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг хэлэлцэн Захиалагчид хүргүүлэх, хэлэлцэн шийдвэрлэх.

<u>Хэлэлцсэн нь</u>

Ж.Бямбажав: "Амны хаалт" нийлүүлэх МРЦМ/202112433 дугаар бүхий сонгон шалгаруулах нээлттэй сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын албан ёсны веб сайтаас татаж авсан жишиг баримт бичгийн загварыг ашиглан боловсруулсан болно. Үнэлгээний хорооны гишүүд уншиж танилцана уу.

Б.Бадамцэнд: Тухайн тендерийн төсөвт өртөг болон хэрхэн төлөвлөгдөж байгаа вэ?

Ж.Бямбажав: Нийт 115,100,000.00 төгрөгний төсөвт өртөг бүхий тендер бөгөөд үүн дотор "Бор-Өндөр" УБҮ-ийн ажиллагсдад олгох 30,000 ширхэг N95 амны хаалт, "Шижир-Алт" алтны үйлдвэрийн ажиллагсдад олгох 1,200 ширхэг амны хаалт N95 амны хаалт , 10,000 ширхэг нэг удаагийн амны хаалт, 100 ширхэг тогооч нарт ашиглах амны хаалт зэрэг багтсан болно.

Н.Гантулга: Үнэлгээний хорооны гишүүдэд өөр санал байхгүй бол тендерийн баримт бичгийг боловсруулан гарын үсэг зураад Захиалагчид хүргүүлэн батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Үнэлгээний хорооны

| | | |
|---|---|---|
| Дарга | ____________________ | Н.Гантулга |
| Гишүүд: | ____________________ | Б.Бадамцэнд |
| | ____________________ | А.Энхцэцэг |
| | ____________________ | Ц.Цэрэндаш |
| Нарийн бичиг: | ____________________ | Ж.Бямбажав |

"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ Танаа

**Тендер шалгаруулалт, үнэлгээний дүгнэлтэд хийсэн хяналтын хуудас**

**Огноо: 2021.03.18** **Дугаар: ДХ-21/03-94**

| № | Үзүүлэлт | Тодорхойлолт | |
|---|---|---|---|
| 1 | Хяналт хийх үндэслэл | ТбОНӨХБАУХАТ хуулийн 46-р зүйлийн 46.1.2 дахь заалт, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журмын 6.2, 7.1 дэх хэсэг. */Сангийн сайдын 2014 оны 212-р тушаал/* | |
| 2 | Тендерийн нэр, дугаар | "Эм, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх | МРЦМ/202112336 |
| 3 | ТШалгаруулалтын ангилал, журам | Бараа | ХА |
| 4 | ТББ батлагдсан огноо, төсөвт өртөг, | 2021 | 17,593,600 ₮ |
| 5 | Тендер зарласан огноо, нээсэн огноо | 2021.02.18 | 2021.03.01 |
| 6 | Тендерийн үе шат, оролцогчийн тоо | Хоёр дахь удаа | 1 оролцогчтой |
| 7 | ҮХ-г байгуулсан огноо, дугаар | 2021.01.14 | А/81 тоот тушаал |
| 8 | ҮХ-ны дарга, НБДарга нарын нэрс | Т.Энхболд | Ё.Хэрлэнбаяр |
| 9 | ҮХ гишүүдийн АЗ зөвшөөрөл,мэдүүлэг | Баталгаажуулж хавсаргасан | ЭБАТ-д мэдүүлсэн |
| 10 | Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр | • <u>**Гэрээ байгуулах эрх олгох**</u><br>***Шалгарсан: "Фарм трейд" ХХК.***<br>***Үнийн дүн: 16,778,330 төгрөг***<br>Бүх тендерээс татгалзах<br>ТББ-д зохих өөрчлөлт оруулах<br>ХА-р дахин зарлах<br>Гэрээ шууд байгуулах | |

## *Дүгнэлт*

<u>Зөрчилгүй</u>

Тендерийн баримт бичиг болон Үнэлгээний хорооны хянан үзэх, үнэлэх шатны маягт, хурлын тэмдэглэл, шийдвэрүүдийг хянан үзэхэд уг тендерийг ТбОНӨХБАУХА тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 194-р тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Тендерийн үнэлгээний заавар"-ын дагуу үнэлсэн байна.

## Зөвлөмж

Захиалагчид:

Үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу шалгарсан оролцогчид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулахыг ЗӨВЛӨЖ байна

*Үнэлгээний хорооны дарга, нарийн бичиг нарт хяналтын дараахь Санамж:*

*1.Тендерийн хүчинтэй хугацаанд багтааж холбогдох шийдвэрийг гаргаж, үр дүнг цахим системд оруулах.*

*2.Тендерийн баримт бичгийг холбогдох журмын дагуу цэгцлэн, бүрдүүлж архивын нэгж болгох.*

| Хяналт баталгаажуулалт: Дотоод хяналт, мониторингийн хэлтэс | Хэлтсийн дарга ...................... | Ахлах мэргэжилтэн Д.Батсайхан |
|---|---|---|

МОНГОЛРОСЦВЕТМЕТ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
... 22 дугаар хороо
... 45 83 80, 45 84 36

2021.03.19 № 1/647

танай ______________-ны №______________-т

"ФАРМ ТРЕЙД" ХХК-Д

Гэрээ байгуулах эрх олгох тухай

"Монголросцветмет" ТӨҮГ-аас 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зарласан "Эм, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх МРЦМ202112336 дугаартай тендерийн сонгон шалгаруулалтад танай компанийн ирүүлсэн тендер нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан нөхцөл, шалгуур үзүүлэлтийг хангаж тендерийг хянан үзэх шатанд тэнцсэн.

Мөн тендерийг үнэлэх шатанд танай компанийн тендерийн харьцуулах үнэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4-д заасан хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийн шаардлагыг хангасан тул танай тендерийг "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулсан болно.

Иймд танай тендерийн үнийг 16,778,330 төгрөгөөр хүлээн зөвшөөрч, захиалагчийн баталсан төсөвт өртөгт багтсан тул мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг үндэслэн гэрээ байгуулах эрх олгож байгааг үүгээр мэдэгдье.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 хоногийн дотор тендер хүчинтэй байх хугацаанд гэрээний маягтыг баталгаажуулан ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ

MONGOLROSTSVETMET
МОНГОЛРОСЦВЕТМЕТ
ТӨҮГ

0930